



**ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖ**

2017 оны 11 сарын 09 өдөр

Дугаар А/66

Улаанбаатар хот

**Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн
төсөл сонгон шалгаруулах тухай**

Монгол Улсын Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалт, Газрын тухай хуулийн 22¹ дугаар зүйлийн 22^{1.1} дэх заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тодорхой байршилд аж ахуйн нэгж байгууллагад төсөл сонгон шалгаруулах зарчмаар эзэмшүүлэх, ашиглуулах газрын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх, ашиглуулах төслийн материалыг зохих журмын дагуу хүлээн авах ажлыг Газрын асуудал эрхэлсэн мэргэжилтэн /Ш.Амартүвшин/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Захирагчийн Ажлын алба /М.Энхбаяр/-нд даалгасугай.

ЗАХИРАГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.БАТНАСАН

0001001